



ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДАРГЫН
ТУШААЛ

2024 оны 06 сарын 23 өдөр

Дугаар А/224

Улаанбаатар хот

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах
тухай

Иргэний нисэхийн ерөнхий газрын Хөдөлмөрийн дотоод журмын 4.5.1, Иргэний нисэхийн үндэсний төвийн дүрмийн 3.1.2, 4.3.1, 4.3.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Иргэний нисэхийн үндэсний төвийн даргын 2020 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн А/190 дугаар тушаалаар томилогдсон Нислэгийн хөдөлгөөний удирдлагын шинэ төвийн ашиглалтын бэлтгэл ажлыг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд хэрэгжүүлэх ажлын цар хүрээг харгалзан дараах гишүүдийг нэмж оруулсугай. Үүнд:

Б.Золбаяр	Холбоо, навигаци, ажиглалтын албаны Ажиглалтын хэсгийн радиолокаторын автоматжуулалтын ахлах инженер
Т.Оюунтуул	Холбоо, навигаци, ажиглалтын албаны Холбооны хэсгийн радио холбооны ээлжийн инженер
С.Золбаяр	Холбоо, навигаци, ажиглалтын албаны Навигацийн хэсгийн Цамхгийн холбоо, ажиглалтын системийн тасгийн мэдээллийн технологи, автоматжуулсан системийн инженер
С.Бат-Эрдэнэ	Нүүлгэн шилжүүлэлтийн ажлын хэсгийн мэргэжилтэн

2. Иргэний нисэхийн үндэсний төвийн даргын 2020 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн А/190 тушаалын хавсралтаар батлагдсан ажлын хэсгийн удирдамжид дараах заалтыг нэмсүгэй. Үүнд:

“14. Засгийн газрын тохируулагч агентлаг Үндэсний хөгжлийн газрын даргын 2020 оны А/56 дугаар тушаалаар батлагдсан “Төслийн техник, эдийн засгийн урьдчилсан судалгаа хийх аргачлал”-ын дагуу “Бүсийн нислэгийн хөдөлгөөний бүсийн хоёрдогч төвийн урьдчилсан техник, эдийн засгийн үндэслэл”-ийг боловсруулах.”

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, хүний нөөцийн газар /Р.Амарбаясгалан/-т үүрэг болгосугай.

ДАРГА



П.МӨНХЖАРГАЛ

1721 01 1308